



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 13/14

Улаанбаатар хот

Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/423 дугаар захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 8 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй хавсралтад заасан нийт 40,000,000.00 (дөчин сая) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Баянгол дүүргийн Цагдаагийн газар, Баянзүрх дүүргийн Цагдаагийн газар, Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газар, Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар, Хан-Уул дүүргийн Цагдаагийн газрын балансад тус тус шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (О.Ганбат)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж Баянгол дүүргийн Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг), Баянзүрх дүүргийн Цагдаагийн газар (П.Нэмэхбаатар), Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газар (Г.Давааням), Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар (Ц.Амгалан-Энх), Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар (Т.Дамбийням)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В. Оюумаа* В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны дүгээр сарын 10-ны өдрийн дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн цагдаагийн удирдах газар

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2024 оны 08 сарын 31-ны өдрийн байдлаар/	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Бусад үндсэн хөрөнгө										
1	Асар (сууц 6*12)	12/11/2023	ш	1	6,900,000.00	6,900,000.00	517,500.00	6,382,500.00	Нийслэлийн цагдаагийн удирдах газар	Баянгол дүүргийн цагдаагийн газар
2	Асар (сууц 6*12)	12/11/2023	ш	2	6,900,000.00	13,800,000.00	1,035,000.00	12,765,000.00		
3	Асар (сууц 6*12)	12/11/2023	ш	1	6,900,000.00	6,900,000.00	517,500.00	6,382,500.00		
4	Асар (сууц 6*12)	12/11/2023	ш	1	6,200,000.00	6,200,000.00	2,686,666.64	3,513,333.36		
5	Асар (сууц 6*12)	12/11/2023	ш	1	6,200,000.00	6,200,000.00	2,686,666.64	3,513,333.36		
	НИЙТ ДҮН			6	33,100,000.00	40,000,000.00	7,443,333.28	32,556,666.72		